

ТЭНГЭР ДААТГАЛ ХК-ИЙН**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 03 сарын 06 өдөр

Улаанбаатар хот

Тэнгэр Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдөр 12:00 цагаас 13:45 цагийн хооронд Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, Галлериа Улаанбаатар төв, 3-р давхар, "JUULCHIN SKY BALLROOM"-д хуралдав. Санал хураалт болон асуултыг www.investmentexpo.mn цахим хаягаар хураав.

Хурлын дарга: Шаравпэлжээ овогтой ГАНТУЯА**Хурлын нарийн бичгийн дарга:** Балдан овогтой ЭНХТҮВШИН**Тооллогын комисс:** Т.Батмагнай /Хуульч/

Ж.Ууганбилэг /Хууль хянан нийцүүлэлтийн мэргэжилтэн/

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: 29**Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо:** 54,686,830 ширхэг**Хурлын ирц:** 91,14 хувь.**НЭГ. МЭДЭЭЛЭЛ**

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин “Тэнгэр Даатгал” ХК-ны хувьцаа эзэмшигчдийн бус ээлжит хурлыг зарлан хуралдах шийдвэрийг 2025 оны 01 сарын 24-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит бус хурлаас шийдвэрлэсэн тухай мөн уг шийдвэрийн дагуу 2025 оны 01 сарын 27-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хүргүүлсэн тухай танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 2025 оны 02 сарын 06-ны өдөр, 2025 оны 02 сарын 29-ны өдрүүдэд тус тус мэдээлээснийг танилцуулав.

Хурлын зар болон хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хорооны 244 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу 2025 оны 02 сарын 01-ны өдрийн дотор брокер, дилерийн компаниудад цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүргүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлын материалтай танилцах боломжоор хангаж ажилласан болохыг мэдэгдэв.

Мөн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрийг 2025 оны 02 сарын 13-ны өдрөөр тогтоосныг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Т.Батмагнай: Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц хураалтын аргачлал болон “Тэнгэр Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр томилогдсон Тооллогын комиссоос ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах болсон шалтгаан, хуулийн үндэслэлийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Ш.Гантуяа нээлтийн үг хэлсэнээр хурал албан ёсоор эхлэв.

ХОЁР. ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1 дүгээр асуудал: Компанийн шинэчлэгдсэн дүрэм батлах;

2 дугаар асуудал: Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны батлах;

3 дугаар асуудал: Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;

1 ДҮГЭЭР АСУУДАЛ:

Компанийн шинэчлэгдсэн дүрэм батлах;

Танилцуулсан: Тэнгэр Даатгал ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга:

Тэнгэр Даатгал өмнө нь хязгаарлагдмал хариуцлагатай компани байсан бөгөөд энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн шинэчлэгдсэн хувьцаат компанийн дүрмийг батлуулж улсын бүртгэлд бүртгүүлснээр Тэнгэр даатгал компани нь Хувьцаат компани болохыг тайлбарлав.

2 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны батлах;

Компанийн шинэчлэгдсэн дүрэм батлах;

Танилцуулсан: Тэнгэр Даатгал ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга:

Компанийн ТУЗ-ийн дарга болон ердийн гишүүн, хараат бус гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин урамшуулал 274,0 сая төгрөг, Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурлын зардал 20,0 сая төгрөг, Бичиг хэргийн зардал 6,0 сая төгрөг нийт 300,0 сая төгрөгийн төсвийг батлуулахаар танилцуулав.

3 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;

Компанийн шинэчлэгдсэн дүрэм батлах;

Танилцуулсан: Тэнгэр Даатгал ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга:

Тэнгэр Даатгал нь Хувьцаат компани болсон тул Толоолон удирдах зөвлөлийн 9 гишүүнтэй болж байгаа тул Компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, үүнтэй холбогдуулан Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгож байгааг тийлбарлав,

ТУЗ-ийн ердийн гишүүнд дараах 6 хүн нэр дэвшсэнийг танилцуулав: Үүнд

- | | |
|-------------|------------------------------|
| 1. Хатагтай | Ш.Гантуяа (ердийн гишүүн) |
| 2. Ноён | Т.Батзул (ердийн гишүүн) |
| 3. Ноён | Ж.Баатарболд (ердийн гишүүн) |
| 4. Ноён | Д.Нямрэнцэн (ердийн гишүүн) |
| 5. Ноён | Б.Батхишиг (ердийн гишүүн) |
| 6. Ноён | Г.Ганзориг (ердийн гишүүн) |

ТУЗ-ийн хараат бус гишүүнд дараах 4 хүн нэр дэвшсэнийг танилцуулав. Үүнд:

- | | |
|-------------|------------------------------------|
| 1. Ноён | Ц.Түмэнцогт (хараат бус гишүүн) |
| 2. Ноён | Ж.Дэлгэрсайхан (хараат бус гишүүн) |
| 3. Хатагтай | Г.Туул (хараат бус гишүүн) |
| 4. Ноён | Р.Амаржаргал (хараат бус гишүүн) |

Хурлын дэгийн дагуу хурлын материалыг танилцуулсны дараа хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдээс асуулт асууж хариулав.

Асуулт №1: Тэнгэр даатгал нь яагаад хувьцаат буюу нээлттэй компани болсон бэ?

Хариулт Гүйцэтгэх захирал Б.Баянмөнх: Тэнгэр Даатгалын томоохон хувьцаа эзэмшигч Мандал Санхүүгийн Нэгдэлийн зорилго бол хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, ард иргэд хөрөнгийн зах зээлээс өгөөж олох боломжийг олгох гол зорилготой ажилдаг. Үүний хүрээнд өөрийн эзэмшиж байгаа компанийг нээлттэй компани болгож Тэнгэр даатгалын хувьцаа эзэмшигч нарыг тухайн компанийн ашгаас өгөөж хүртэх боломжийг олгохоор энэхүү шийдвэрийг гаргасан.

Асуулт №2: 2025 оны ашгаас ногдол ашиг тараах эсэх.

Хариулт ТУЗ-ийн дарга Ш.Гантуяа: Өмнө нь гүйцэтгэх захирал Б.Баянмөнх хэлсэнчлэн бид Тэнгэр даатгалын хувьцаа эзэмшигч нарыг хөрөнгийн зах зээлээс өгөөж олгох боломжийг олгохоор зорьж байгаа. Тиймээс би түрүүн хэлсэн Тэнгэр Даатгал ХК маань 2024 оны татварын дараах цэвэр ашгаасаа 4,0 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн. Ирэх жил буюу 2025 он болон ойрын 3 жилд бид цэвэр ашгаасаа ногдол ашиг олгохоор зорих болно. Гэхдээ ногдол ашиг олгох эсэх шийдвэрийг энэхүү хурлаар сонгогдож байгаа ТУЗ-ийн шинэ гишүүд гаргана гэдгийг та бүхэн ойлгож байгаа байх аа.

Асуулт №3: Тэнгэр даатгал Мандал даатгал топ хувьцаа эзэмшигч нь нэг компани байна. Хоорондоо өрсөлдөгч гэж харж байгаа юу?

Хариулт ТУЗ-ийн дарга Ш.Гантуяа: Миний нээлт дээр танилцуулсан танилцуулга дээр одоогоор нээлттэй байгаа 5 даатгалын компанийн санхүүгийн үзүүлэлтийг та бүхэнд харуулсан.

Нээлттэй даатгалын компаниуд дундаас цэвэр ашиг болон хэмжээгээрээ Мандал Даатгал нэгд дараа нь Тэнгэр даатгал маань орж байгаа. Бид чөлөөт зах зээлд үйл ажиллагаагаа явуулж байгаа учир өрсөлдөгчөө гэж харж байгаа Мандал Даатгалыг. Цэвэр ашиг болон бусад үзүүлэлтээрээ ирэх жилүүдэд Мандал Даатгалыг гүйцнэ гэдэгт итгэлтэй байна.

Асуулт №4: 2025 оны бизнесийн гол гарц юу вэ, гол ажлууд юу байна? Нүүрсний үнийн уналт, АНУ, Хятадын хоорондын нөхцөл байдал Монголын ЭЗ ба Тэнгэр даатгалд яаж

нөлөөлнө гэж харж байгаа үз? Эрсдэл ба боломжид чиглүүлэн ямар ажлууд төлөвлөж байна?

Хариулт Гүйцэтгэх захирал Б.Баянмөнх:

Сүүлийн үед олон улсад эдийн засгийн нөхцөл байдал сайнгүй байгаа байдал харагдаж байна. Америк болон Хятад улсын хоорондын нөхцөл байдал сайнгүй байгаа үүнээс шалтгаалан Монголын эдийн засагт нүүрсний үнийн уналт, Хятад улсын нүүрсний хэрэглээ багсах гэх мэт тодорхой хэмжээгээр нөлөөлнө. Даатгалын компанийг тухайн улсад хэр нэвчсэн байгаа нэг хүн хэдэн даатгалтай байгаагаар, харин тухайн улсад даатгал хэр хөгжиж байгаа даатгалын нийт хураамж тухайн улсын ДНБ-ийн хэдэн хувийг эзэлж байгаагаар хэмжиж болдог. Олон улсад нэг хүн 8 даатгалтай байдаг бол Монгол улсад 8 хүний 1 нь даатгалтай байна. Олон улсад ДНБ-ийн 7-8 хувийг эзэлдэг бол Монгол улсад 0,6 хувь байна. Энэ бүхнээс харвал бидэнд маш их боломж байгаа гэж харж байна.

САНАЛ ХУРААЛТ

Танилцуулсан: Тооллогын комиссын дарга Т.Батмагнай

КОМПАНИЙН ШИНЭЧИЛСЭН ДҮРМИЙГ БАТЛАХ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

“Тэнгэр Даатгал” ХК-ийн шинэчлэгдсэн дүрмийг батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 51,936,825 ширхэг хувьцааны санал буюу 94,9 хувийн саналаар Тэнгэр Даатгал компанийн шинэчилсэн дүрмийг батлав.

КОМПАНИЙН ТУЗ-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

ТУЗ-ийн 2025 үйл ажиллагааны зардлын төсөв батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 51,936,698 ширхэг хувьцааны санал буюу 94,9 хувийн саналаар ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлав.

КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгоход өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 492,181,470 ширхэг саналыг дараах байдлаар ТУЗ-ийн нэр дэвшигч гишүүдэд өгснөөр батлав. /Кумулятив аргаар санал хураасан/ Үүнд:

Ердийн гишүүнд нэр дэвшигчид	Кумулятив саналын тоо	Хувь
Шаравпэлжээ овогтой Гантуяа	53,800,620	10.93 %
Түмэннасан овогтой Батзул	53,090,156	10.79 %
Жуков овогтой Баатарболд	50,820,825	10.33 %
Дорж овогтой Нямрэнцэн	68,095,051	13.84 %
Бадарч овогтой Батхишиг	52,115,152	10.80 %
Ганбат овогтой Ганзориг	53,165,152	10.80 %

Хараат бус гишүүнд нэр дэвшигчид	Кумулятив саналын тоо	Хувь
Цэвэгмид овогтой Түмэнцогт	52,909,048	10.75 %
Ринчинням овогтой Амаржаргал	6,845,262	1.39 %
Жамсрандорж овогтой Дэлгэрсайхан	50,685,105	10.30 %
Галзагд овогтой Туул	50,655,040	10.29 %

Тооллогын комиссын дарга Т.Батмагнай: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга “Тэнгэр Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал амжилттай болсныг ТУЗ-ын нарийн бичгийн дарга зарласнаар 13 цаг 45 минутад хурал өндөрлөв.

~~ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:~~

~~Б.ЭНХТҮВШИН~~

~~Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга~~

ТАНИЛЦСАН:

Ш.ГАНТУЯА
Хурлын дарга

